



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/38

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулах ажил, Хогны менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Гишүүд: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
А.Долгор-Өлзий (Иргэний төлөөлөл)

2.Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Янжиндулам)-д даалгасугай.

ДАРГА



С.АМГАЛАН